



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Онцгой комиссын шуурхай бүлгийн үйл
ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/213 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт шар усны үерээс урьдчилан сэргийлэх, малчид хаваржилтыг хохирол багатай даван туулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, Онцгой комиссын шуурхай бүлгийн шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-д үүрэг болгосугай.

2.Шуурхай бүлгийн үйл ажиллагаанд шаардагдах 2,029,000 (Хоёр сая хорин есөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 137 дугаар
захирамжийн хавсралт



ШУУРХАЙ БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЭРЧИМЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Материалын нэр		Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төг)	Шаардагдах хэмжээ	Бүгд
1.	Дүүргийн Онцгой комиссын даргын ажлын болон шийдвэрийн зураг хэвлүүлэх (100,000 масштабтай)		ш	250,000	2	500,000
2.	Онцгой комиссын даргын ажлын болон шийдвэрийн зургийг байрлуулах хөл		ш	100,000	2	200,000
3.	Зөөврийн интернэт төхөөрөмжийн төлбөр		ш	25,000	3	75,000
4.	Урьдчилан сэргийлэх Мессеж багцын төлбөр		ш	25,000	12 сар	300,000
5.	Иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх гарын авлага тараах материал хэвлэх		ш	500	1000	500,000
6.	Шуурхай штаб, бүлгийн зөөврийн баннер		ш	100,000	2	200,000
7.	Бичиг	Бичгийн цаас	боодол	20,000	4	80,000
	хэргийн	Фото цаас	боодол	12,000	2	24,000
	зардал	Калкин цаас	ш	300	500	150,000
Бүгд						2,029,000